БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ
"ХОТЫН СОЁЛ" АЯНЫ ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН

2021 оны 11 дүгээр сарын 25 Багануур дүүрэг

**1. Байгууллагын соёл, албан хаагчдын ёс зүйн хандлага, харилцааны соёлыг төлөвшүүлэх чиглэлээр дотооддоо сургалт зохион байгуулах, иргэдэд үзүүлж буй үйлчилгээндээ чирэгдэлгүй түргэн шуурхай байх**

11 дүгээр сарын 22-ны өдөр цахим соёл түгээх зорилгоор нийгмийн сүлжээндэх стрессээс хэрхэн сэргийлэх, эх сурвалж тодорхойгүй мэдээлэлд автахгүй, хуваалцахгүй байх, үг үсэг, утга найруулгын алдаагүй зөв бичих, боловсон харилцааг эрхэмлэх талаар чөлөөт хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Хөрөнгө оруулагчид, иргэдээс ирүүлсэн хүсэлтийг цахимаар хүлээн авч, шаардлагатай мэдээ, мэдээллийг өдөрт нь, судалгааны чиглэлийн мэдээ мэдээллийг ажлын 3 өдөрт багтаан шуурхай хүргэн ажилладаг.

Байгууллагын албан хаагчид Соёлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган соёлын талаарх иргэний үүргээ биелүүлэн ажиллаж байна.

**2. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Соёл, урлагийн газраас бэлтгэсэн соён гэгээрүүлэх нөлөөллийн контент, нэвтрүүлэг, зурагт хуудсыг байгууллагын олон нийтийн сүлжээний цахим хуудас болон албан хаагчдын хувийн фейсбүүк хуудсаар дамжуулан сурталчлах, давалгаалуулах ажлыг зохион байгуулах**

"Нийслэлийн Соёл, урлагийн газар" фейсбүүк хуудсанд тавигдсан "Аж ахуйн нэгж байгууллагын 2021 оны улсын тооллогод идэвхтэй хамрагдацгаая", "Соёлтой хотод хамтдаа амьдарцгаая", "Улаанбаатар хотын орчин үеийн соёлын түүх" сэдэвт эрдэм шинжилгээний 9 дүгээр хурал, "3 дахь тундаа хамрагдая, Хамтдаа хичээцгээе", "Хотын түүхийг 2 минутанд", "Хот төлөвлөлт ба хотын стандарт" видео, "Их хотын эртэч хүмүүс" цуврал нэвтрүүлэг, "Пөөдөө" үзэсгэлэнгийн нээлт, "Бидний тухай бид", "Хотын түүхийг 2 минутанд" зэрэг мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулан олон нийтэд түгээж байна. Цахим хуудаснаас мэдээллийг уншсан тоо – 66





**3. Аяны хүрээнд шинээр ажил санаачлан олон нийтэд сурталчлах**

Монгол өв соёлыг дээдлэх, хадгалах, түгээх зорилгоор "Номоор ухаажья, Ухаанаар баяжья" уриалгыг гарган цахим хуудсанд байршуулсан. Цахим хуудаснаас уриалгыг уншсан тоо – 28

Албан хаагчид монгол хэл болон монгол бичгээр хэвлэгдэн гарсан эртний түүх соёл, роман, тууж зэрэг номыг солилцон ухаанаа тэлж, үгийн санг баяжуулах ажлыг зохион байгуулсан.




ХЯНАСАН:
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА Ч.ЭЛБЭГСАЙХАН

ТАЙЛАН ГАРГАСАН:
МАРКЕТИНГ, ОЛОН НИЙТИЙН ХАРИЛЦАА,
ХОТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Ч.БАЯРЦЭЦЭГ